БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ-ЫН
АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

2023 оны 12 дугаарр сарын 14 Багануур дүүрэг

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|
| | **НЭГ.ЭРҮҮЛ ЧИЙРЭГ ХАМТ ОЛНЫГ БҮРДҮҮЛЭХ** | | |
| 1. | Ажлын байранд өглөө 11:00, өдрийн 15:00 цагуудад 10-15 минутын дасгал хөдөлгөөнийг өдөр бүр зохион байгуулах | Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1059 дүгээр захирамжаар Нийслэлийн Засаг даргын нэрэмжит Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын спортын V наадмын тэмцээний хүрээнд холбогдох төрлөөр дартс,болон ширээний одон бөмбөгийн тэмцээнийг байгууллагадаа зохион байгууллаа. | 100% |
| 2. | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулах | Ажилтан, албан хаагчдын нийгэм, эрүүл мэнд, эдийн засгийн баталгааг хангах арга хэмжээний хүрээнд "Шиномед" эмнэлэгт "эрт илрүүлэг" иж бүрэн үзлэг оношлогоонд 5 сарын 24 өдөр нийт ажилтнуудыг бүрэн хамруулж эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний үйлчилгээг авлаа. 2023 он гарсаар "Эрүүл мэндийн эрт илрүүлэг" үзлэг шинжилгээний багцад хамрагдах албан хаагчдын судалгааг насны бүлэгээр /31-45, 46-60, 61-с дээш/ гарган дүүргийн эрүүл мэндийн төвд хүргүүллээ. Албан хаагчид ажилтны эрүүл мэнд болон нийгмийн асуудалд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд нүдний харааг шалгуулах болон бусад төрлийн үзлэг шинжилгээнд хамрагдах ажлыг зохион байгууллаа | 100% |
| | **ХОЁР.АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХ** | | |
| 3. | Албан хаагч нарт ажиллах тав тухтай орчныг бүрдүүлэх | Цахилгаан, дулаан, гэрэлтүүлэг, техник хэрэгсэл, ажлын эмх цэгц, ая тухтай орчин бүрдүүлэх зэрэгт энгийн нөхцлийн дотоод хяналтыг зохион байгууллаа. Илэрсэн | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | зөрчил үгүй. Гэрэлтүүлэгийн ламп шатсаныг сольлоо. Албан хаагчдын ажиллах ая тухтай орчин бүрдсэн. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй сарын аяны ажлын хүрээнд ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуй, ая тухтай орчинг бүрдүүлэх тал дээр дотоод хяналтыг жилдээ 1 удаа зохион байгуулж байна. 1 хүнд ногдох ажлын талбай, м3 хэмжээ хангалттай байна.. | |
| 4. | Шаардлагатай компьютерийн техник хэрэгслийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, цахим орчны аюулгүй байдлыг хангах | Байгууллагын албан хэрэгцээний хэвлэх принтер гацдаг болсон тул шаардлага хангасан хэвлэгч хэрэгцээтэй байгааг уламжлаад байна. Шаардлагатай техник хэрэгсэл, ажлын компьютер, бусад хэрэглээр бүрэн хангагдсан. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй сарын аяны хүрээнд ажлын байрны эрүүл ахуй “Компютерийн зөв хэрэглээ, аюулгүй байдал зөвлөмж”-ийг өгч ажиллалаа. | 100% |
| **ГУРАВ.АЛБАН ХААГЧДЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИНГ НЭМЭГДҮҮЛЭН, ТУСЛАМЖ ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ** | | | |
| 5. | Албан хаагчдын ажлын гүйцэтгэл болон хөдөлмөрийн гэрээг дүгнэж хамт олны хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, ур чадвар үр дүнгийн урамшуулал олгох | 2023 оны жилийн эцсийн гйүцэтгэл, үр дүнг үнэлэх үнэлгээ хийв. Байгууллагын албан хаагч нарын ажлын гүйцэтгэл болон хөдөлмөрийн гэрээг дүгнэх, үр дүнгийн биелэлтийг үнэлж, дотоод журмын дагуу ур чадварын болон үр дүнгийн урамшуулал олгосон. | 100% |
| 6. | Албан хаагчдад хоол унааны мөнгө олгох | Албан хаагчдад олгох хоол унааны мөнгийг сар бүрийн цалин дээр бодон олгож байна. | 100% |
| 7. | Албан хаагч нарын ажлын гүйцэтгэл, үр дүн, ажилласан хугацаанд үндэслэн төрийн одон медаль, салбарын болон нийслэл, дүүргийн шагналуудад тодорхойлох | Албан хаагч нарын ажлын гүйцэтгэл, үр дүн, ажилласан хугацааны нэмэгдэл болон цалин, урамшуулал, шагнал зэрэг нийгмийн баталгааг хангах тал дээр анхааран ажиллаж байна. Байгууллагад 30 гаруй жил ажиллаж байгаа 2 ахмад албан хаагчийг хөдөлмөрийн хүндэт болон алтан гадас одонд тодорхойлсны нэг албан хаагч төрийн одонгоор шагнуулж 2 залуу боловсон хүчин мөн шагнагдлаа. | 100% |
| 8. | Албан хаагчдын ар гэрт гачигдал гарсан тохиолдолд цалинтай чөлөө олгож, тусламж үзүүлэх | Албан хаагчдын ар гэрт гачигдал гарсан тохиолдолд дотоод журмын дагуу ажлыг зохицуулж цалинтай чөлөө олгох, тусламж үзүүлэх зэргээр дэмжлэг үзүүлдэг бөгөөд | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | 2023 он гарсаар мэргэжилтэн Энхбатын ар гэрт гачигдал гарсанд 500,000 төгрөгийн тэтгэмж олгов. | |
| 9. | Албан хаагч 3 сараас дээш хэвтэн эмчлүүлсэн тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн 43.3.4. дэх заалтыг үндэслэн албан тушаалын чиг үүрэг нь хамгийн ойр хамааралтай албан хаагчаар, эсхүл төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн иргэнийг сонгон авч, тодорхой хугацаагаар түр орлон гүйцэтгүүлж, ажлын байрыг хэвээр хадгалж, мөнгөн тусламж үзүүлэх | Төрийн албаны тухай хуулийн 43.3.4. дэх заалтын хүрээнд хамаарах хөдөлгөөн, зохицуулалт хийгдээгүй.<br>Албан хаагчид чиг үүргийн хүрээнд хэвийн бүрэн ажилласан. | 100% |
| 10. | Нийслэл болон дүүргээс зохион байгуулах нийгмийн хариуцлагын чиглэлийн үйл ажиллагаанд хамт олныг оролцуулах | Нийслэл болон дүүргээс зохион байгуулж буй нийгмийн хариуцлагын чиглэлийн үйл ажиллагаанд хамт олныг оролцуулан зохион байгуулж байна.Дүүргийн Тамгын газраас зохион байгуулсан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан зөвлөгөөн болон "Эрсдэлгүй амьдрал" архины хор хөнөөл сэдэвт сургалтад байгууллагаас 3 албан хаагч хамрагдаж нөлөөллийн арга хэмжээг дэлгэрүүлэх тал дээр ажиллалаа.<br>Мөн бусад аян, арга хэмжээнд хамрагдаж байна. | 100% |
| **ДӨРӨВ.АЛБАН ХААГЧ МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ** | | | |
| 11. | Албан хаагч нь 5 ба түүнээс дээш хоногийн танхимын сургалтанд хамрагдах тохиолдолд цалинтай чөлөө олгох | 5 ба түүнээс дээш хоногийн танхимын сургалтанд хамрагдсан албан хаагч байхгүй | 100% |
| | | **Хэрэгжилтийн дундаж** | 100% |

ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА Ч.ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Д.МӨНХТОГТОХ